



КОРОНАВИРУС БА ЭДИЙН ЗАСАГ

4 сар



Улаанбаатар хот
2020.05.25

COVID-19 цар тахлын дэгдэлттэй холбогдуулан Монгол Улсын 2020 оны эхний 4 сарын эдийн засаг, нийгмийн төлөв байдлыг

танилцуулъя.

ҮСХ-ноос 2020 оны 5-р сарын 20-ны өдөр тархаасан нийгэм, эдийн засгийн байдлын статистик мэдээллээр 2020 оны эхний улирлын байдлаар улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс


- ДНБ 10.7%,
- Уул уурхайн салбар 29.5%,
- Жижиглэн худалдааны борлуулалт 11.5%,
- Нийтийн хоолны салбарын орлого 2.6%,
- Зочид буудлын салбарын орлого 42.9% тус тус буурч,
- Төлбөрийн тэнцэл 767.0 сая ам.долларын алдагдалтай гарч, харин
- Хөдөө аж ахуйн салбар 14.0%,
- Аж үйлдвэр, барилгын салбар 6.4%
- Ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон тэтгэмжийн хэмжээ 43.0% тус тус өсжээ.



1. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, БУУРАЛТ

Олон улсын валютын сангийн 2020 оны 1 дүгээр сарын тайланд энэ оны Дэлхийн эдийн засгийн өсөлт 3.3 хувь байна гэж төсөөлж байсан бол 4 дүгээр сарын тайланд COVID-19 цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг 3.0 хувь буурна гэж таамаглажээ.

Зураг 1. Дэлхийн ДНБ-ны өсөлтийн таамаглал, COVID-19 цар тахлын өмнө болон цар тахлын үед¹



Азийн Хөгжлийн Төлөв 2020 тайланд тусгаснаар АХБ Монгол Улсын 2020 оны эдийн засгийн өсөлтийг, дэлхийн болон бүс нутгийн эдийн засагт COVID-19 цар тахлын үзүүлж буй сөрөг нөлөөллийн улмаас мэдэгдэхүйц буурч, 2.1 хувь байхаар төсөөлжээ.² ДНБ-ны 2020 оны 1 дүгээр улирлын дүнгээс харахад энэ нь нилээд өөдрөг төсөөлөл байх магадлалтай байна.

¹ <https://www.statista.com/chart/21397/global-gdp-growth-forecasts-before-and-during-the-covid-19-pandemic/>

² <https://www.adb.org/countries/mongolia/economy>


ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2020 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 3,148.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 377.2 (10.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 269.2 (29.5%) тэрбум төгрөгөөр, үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 114.9 (6.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. COVID-19 цар тахлын дэгдэлт болон БНХАУ-ын эдийн засгийн удаашралын улмаас ашигт малтмалын түүхий эдийн эрэлт багассан нь Монгол Улсын нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, газрын тосны экспорт буурч, эдийн засаг агшихад хүргэсэн байна.

Зураг 2. ДНБ-ий 2020 оны эхний улирлын өсөлт, бууралт, салбаруудын оролцоо³



Зураг 3. ДНБ-ий өсөлт, бууралт, уул уурхай, уул уурхайн бус салбараар, хувиар

Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг 2019 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар өсөхөд нийт эдийн засаг 8.6 хувиар өсөж байсан бол 2020 оны эхний улиралд уул уурхай, олборлолтын салбарын үйл ажиллагаа 29.5 хувиар буурснаар нийт эдийн засаг 10.7 хувиар буурахад хүргэсэн байна.



Уул уурхайн бус салбар 2020 оны эхний улиралд нийт дүнгээрээ бууралттай гарсан байна.

Харин хөдөө аж ахуйн салбар 14.0 хувиар, аж үйлдвэр, барилгын салбар 6.4 хувиар өссөн байна.


2. УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны нийт орлогыг 12.9 их наяд төгрөг байхаар баталсан. Үүний 3.2 их наяд төгрөгийг уул уурхайн салбарын орлого, 3.5 их наяд төгрөгийг импорт, 5.1 их наяд төгрөгийг эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлийн орлого, 1.1 их наяд төгрөгийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр тооцсон байна. Өөрөөр хэлбэл, төсвийн орлогын гуравны нэгийг уул уурхайн бүтээгдэхүүн буюу нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, газрын тосыг БНХАУ-д экспортолж, бүрдүүлэхээр тооцжээ.⁴

³ http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=GDP_2020Q1.pdf&ln=Mn

⁴ https://mof.gov.mn/files/uploads/article/%D1%82%D3%A9%D1%81%D3%A9%D0%B2_2020-pdf1.pdf

Зураг 4. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 4 сарын байдлаар, тэрбум төгрөг



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 2.9 их наяд төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 3.3 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 276.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны 4 дүгээр сард 642.4 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 117.8 (15.5%) тэрбум төгрөгөөр буурч, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 970.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 109.9 (12.8%) тэрбум төгрөгөөр

өсжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 85.6 хувийг татварын орлого бүрдүүлж байгаа бөгөөд татварын нийт орлого 2020 оны эхний 4 сард 2.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 404.5 (14.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд бусад татвар, төлбөр хураамжийн орлого 98.6 (33.2%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 64.1 (23.1%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 59.9 (10.0%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 42.2 (6.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

НӨАТ-ын орлого 2020 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өсөж байсан бол 4-р сард 147.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 22.7 хувиар, өмнөх оны мөн үеэс 32.6 хувиар буурчээ. НӨАТ-ын орлого энэ оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар буурахад дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ 4.7 хувиар, импортын барааны НӨАТ 6.2 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

ОАТ-ын орлого 2020 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 23.1 хувиар буурахад дотоодын архи, дарсны ОАТ 30.9 хувь, дотоодын тамхины ОАТ 36.3 хувь, дотоодын пивоны ОАТ 13.0 хувь, импортын архи, дарсны ОАТ 17.0 хувь, суудлын автомашины ОАТ 30.0 хувь, автобензин, дизелийн түлшний ОАТ 20.0 хувиар тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. НӨАТ, ОАТ-ын орлого, сая төгрөг⁵

Үзүүлэлт	2019			2020			2020* I-IV 2019 I-IV
	III	IV	I-IV	III	IV*	I-IV	
Нэмэгдсэн өртгийн албан татвар	108 751.9	218 071.6	599 624.2	190 266.5	146 999.0	539 761.4	90.0
Онцгой албан татвар	63 309.0	63 731.0	277 183.1	48 521.5	33 600.4	213 116.3	76.9

Улсын нэгдсэн төсвийн зарлагын өсөлтөд урсгал зардал 464.2 (18.7%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 68.7 (21.9%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардал 88.5 хувь, хөрөнгийн зардал 11.5 хувийг эзэлж байна.

3. ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ

Үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын борлуулалт 2020 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 4.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.4 (36.6%) их наяд төгрөгөөр буурсан ба цаас, цаасан бүтээгдэхүүн, мод, модон эдлэл, резин болон хуванцар бүтээгдэхүүн, химийн

⁵ http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0800_002V1

бүтээгдэхүүн, тамхи, тавилга, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн борлуулалт 2.5-58.9 хувиар буурсан байна.

Харин хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэлийн борлуулалт 17.2 хувь өсжээ. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2020 оны эхний 4 сард 499.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.1 (3.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар

Салбар	2019		2020*		2020*I-IV 2019 I-IV
	IV	I-IV	IV	I-IV	
	тэрбум төгрөг				хувь
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	126.9	483.3	114.4	499.4	103.3
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	13.7	65.4	14.5	46.9	71.7
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21.2	73.6	20.8	74.8	101.5
Үр тарианы гурил, малын тэжээл	16.1	66.2	20.5	75.1	113.5
Хүнсний бусад бүтээгдэхүүн	18.2	63.7	17.6	71.5	112.2
Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/	57.7	214.4	41.0	231.1	107.8

Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөхөд сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1.1 (1.5%) тэрбум төгрөгөөр, үр тарианы гурил, малын тэжээл үйлдвэрлэл 8.9 (13.5%) тэрбум төгрөгөөр, хүнсний бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7.8 (12.2%) тэрбум төгрөгөөр, ундаа үйлдвэрлэл (согтууруулах ундаа ороод) 16.7 (7.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Харин мах, загас, ногоо, тос боловсруулалт өмнөх оны мөн үеэс 18.5 (28.3%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2019		2020*		2020*I-IV 2019 I-IV
		IV	I-IV	IV	I-IV	
Үхрийн мах	т	28.0	166.9	360.7	665.5	4.0 ¹
Хонины мах	т	44.4	1 154.3	584.1	1 197.4	103.7
Адууны мах	т	1 167.0	4 358.8	-	342.5	7.9
Ямааны мах	т	2.4	109.3	51.1	541.5	5.0 ¹
Хиаман төрлийн бүтээгдэхүүн	т	379.1	1 643.8	370.2	1 526.5	92.9
Шингэн сүү	мян.л	3 478.9	12 878.3	4 240.3	14 755.5	114.6
Тараг	мян.л	1 673.1	5 012.5	1 606.4	5 195.2	103.6
Зайрмаг	мян.ш	10 290.2	23 088.6	13 080.4	21 702.9	94.0
Аарц	т	23.8	160.9	20.8	195.0	121.2
Дээд гурил	т	4 178.4	14 486.2	5 058.3	15 894.2	109.7
Нэгдүгээр гурил	т	10 755.3	47 078.7	12 336.2	51 606.9	109.6
Хоёрдугаар гурил	т	1 042.5	4 638.6	2 078.8	8 324.9	179.5
Талх	т	2 453.2	8 413.7	2 163.5	8 543.7	101.5
Нарийн боов	т	1 986.7	6 826.5	2 117.0	7 141.2	104.6
Бялуу	т	178.2	716.8	196.0	787.2	109.8
Жигнэмэг	т	109.4	336.8	60.0	349.3	103.7
Гоймон	т	848.4	2 839.2	304.8	2 401.6	84.6
Бууз, банш	т	613.6	1 486.4	280.3	968.9	65.2
Савласан ногоон цай	кг	9 595.6	28 662.0	11 222.0	57 443.2	2.0 ¹
Спирт	мян.л	918.7	3 475.1	1 861.4	4 612.9	132.7
Архи	мян.л	2 312.7	8 927.9	1 402.1	7 966.8	89.2
Шар айраг	мян.л	6 949.8	26 460.3	7 086.8	25 460.7	96.2
Цэвэр ус	мян.л	6 541.4	22 364.5	4 101.9	23 683.0	105.9
Амтат ус, ундаа	мян.л	15 953.9	50 607.5	12 210.5	74 051.2	146.3
Жүүс	мян.л	5 373.1	21 154.2	4 288.7	24 297.8	114.9


¹ Дахин их

Талх, нарийн боов, дээд гурил, гоймон, тараг, спирт, нэгдүгээр гурил, бялуу, шингэн сүү, цэвэр ус, жүүс, аарц, жигнэмэг, хоёрдугаар гурил, амтат ус, ундаа, савласан ногоон цай, үхэр, ямааны махны үйлдвэрлэл 2020 оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 1.5 хувиас 5.0 дахин өссөн байна. Харин шар айраг, архи, хиаман бүтээгдэхүүн, бууз, банш, зайрмаг, хонь, адууны махны үйлдвэрлэл 0.8-92.1 хувиар буурсан байна.

4. ИНФЛЯЦ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.6 хувиар буурч, өмнөх оны эцсээс 2.2 хувь, өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар хувиар өссөн байна.

Зураг 5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь өмнөх оны мөн үетэй харьцуулснаар



Инфляцын түвшин 2017 оны 4 дүгээр сард 3.2 хувь, 2018 оны 4 дүгээр сард 6.0 хувь, 2019 оны 4 дүгээр сард 7.0 хувь гарч байсан бол 2020 оны 4 дүгээр сард 4.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр буурсан байна.

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 32 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2020 оны 5 дугаар сарын III долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 20 нэрийн барааны үнэ (62.4%) **ТОГТВОРТОЙ**, 6 нэрийн барааны үнэ (18.8%) **буурсан**, 6 нэрийн барааны үнэ (18.8%) **өссөн** байна..

≈ Үнэ тогтвортой	↓ Үнэ буурсан	↑ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> "Алтан Тариа" задгай гурил I "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд "Алтан Тариа" савласан гурил I "Алтан Тариа" савласан гурил II "Сүү" ХК савласан 1 л сүү "Сүү" ХК савласан 0.5 л сүү Сүү, задгай "Сүү" ХК тараг, Цөцгийтэй Талх, "Атар" Талх, "Зууван чех" Талх, "хөх тарианы хар" Цагаан будаа, "Заантай" Шар будаа Цөцгийн тос, Сүү ХК Ургамлын тос, "Янта" Элсэн чихэр, "Заантай" Төмс, монгол Байцаа, монгол Алим, фүжи Өндөг, ОХУ 	<ul style="list-style-type: none"> Ногоон цай, "Стимо" Үхрийн мах, ястай Үхрийн мах, цул Адууны мах, ястай Ямааны мах, ястай Сонгино, хятад 	<ul style="list-style-type: none"> "Алтан Тариа" задгай гурил дээд "Алтан Тариа" савласан гурил дээд Хонины мах, ястай Хонины мах, цул Лууван, монгол Хүрэн манжин, монгол

Хонины ястай махны үнэ 2020 оны 5-р сарын III долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад 24 төгрөгөөр (0.2%), хонины цул махны үнэ 121 төгрөгөөр (1.2%) тус тус өссөн байна. Хонины ястай мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 8500 төгрөгөөр, харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 12800 төгрөгөөр худалдаалж байна.

Хүснэгт 4. Нэг килограмм хонины ястай махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Хонины ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10 430	10 045	9 700	9 640	9 095	7 710	7 635
2020	8 705	9 600	9 765	9 835	10 146*							

Хонины ястай мах нэг килограмм нь 2020 оны 5-р сарын III долоо хоногт дунджаар 10146 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 11825 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 89 төгрөгөөр (0.7%), үхрийн цул махны үнэ 8 төгрөгөөр (0.1%) тус тус буурсан байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн ястай мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 9500 төгрөг, Харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 14000 төгрөг байна.

Хүснэгт 5. Нэг килограмм үхрийн ястай махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай мах												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11 700	12 280	11 540	11 375	10 950	10 090	9 755
2020	10 535	11 415	11 663	11 735	11 825*							

Үнийн судалгааны сагс дахь нийт 373 нэр төрлийн бараа, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг. Энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн нөлөө 25.5 хувь байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 13.1 пунктээр буурсан байна.

Хүснэгт 6. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 4 дүгээр сард

Үзүүлэлт	2018 IV		2019 IV		2020 IV	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	6.0	100.0	7.0	100.0	4.7	100.0
Импортын барааны нөлөө	2.5	41.7	2.7	38.6	1.2	25.5

5. ЭКСПОРТ, ИМПОРТ

БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн удаашрал, COVID-19 цар тахлын сөрөг үр дагаврын нөлөөллөөр гадаад худалдааны нөхцөл муудаж, экспорт буурснаар төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2020 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 767.0 сая америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 368.9 сая америк доллароор өссөн байна.

Манай улс 2020 оны эхний 4 сард нийт 125 улстай худалдаа хийсэн ч нийт бараа эргэлтийн 58.5 хувийг БНХАУ эзэлж байна. Нийт бараа эргэлт 3.0 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (30.8%) тэрбум америк доллароор буурахад БНХАУ-тай хийсэн нийт экспорт 1.0 (45.0%) тэрбум америк доллароор, импорт 39.4 (7.3%) сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 7. Экспортын гол түнш улсууд, жил бүрийн эхний 4 сарын байдлаар

Улс орон	2018 I-IV		2019 I-IV		2020* I-IV	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн БНХАУ	2 125.4	100.0	2 512.0	100.0	1 373.6	100.0
Их Британи	1 908.1	89.8	2 235.2	89.0	1 228.9	89.5
Швейцар	154.4	7.3	210.1	8.4	58.0	4.2
ОХУ	0.5	0.0	0.2	0.0	32.3	2.3
Сингапур	24.7	1.2	21.7	0.9	17.1	1.2
Бусад	2.9	0.1	4.5	0.2	6.6	0.5
	34.9	1.6	40.3	1.6	30.8	2.2

БНХАУ-д хийсэн экспорт нь манай улсын нийт экспортын дүнгийн 89.5 хувийг бүрдүүлж байна.

БНХАУ-д гаргасан бараа бүтээгдэхүүний 26.3 хувийг чулуун нүүрс, 39.6 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Их Британи улсад экспортолсон барааны 83.2 хувийг алт, ОХУ-д экспортолсон барааны 92.1 хувийг жоншны

экспорт, Итали улсад экспортолсон барааны 57.8 хувийг мал амьтны самнасан үс, хялгас эзэлж байна.

Зураг 6. Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая америк доллароор, жил бүрийн эхний 4 сарын байдлаар



Экспорт 2020 оны эхний 4 сард 1.4 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 1.1 (45.3%) тэрбум америк доллароор буурсан байна. Нийт экспортын 87.8 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт эзэлдэг бөгөөд энэхүү бууралтад алтны экспорт 115.6 сая америк доллар, зэсийн баяжмалын экспорт 215.2 сая америк доллар, нүүрсний экспорт 629.0 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Импорт 2020 оны эхний 4 сард 1.6 тэрбум америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 179.9 сая америк доллароор буурахад автобензины импорт 19.8 сая америк доллар, дизелийн түлшний импорт 58.6 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлжээ.

Монгол Улс эрсдэлийн бүс нутгаас хүнсний бүтээгдэхүүн импортлохгүй байх шийдвэр гаргасантай холбогдуулан 2020 оны эхний 4 сард гахайн махны 75.1 хувь, наранцэцэгийн тосны 96.2 хувийг ОХУ-аас импортолж, цагаан будааны 36.9 хувийг БНХАУ-аас, 23.7 хувийг Вьетнамаас, 20.8 хувийг ОХУ-аас, 6.8 хувийг Казакстанаас, элсэн чихрийн 52.5 хувийг Тайландаас, 30.5 хувийг ОХУ-аас, 12.9 хувийг БНЭУ-аас тус тус импортолсон байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад цагаан будаа, ургамлын тос, элсэн чихэр, гахайн мах, улаан буудайн импорт 11.8 хувиас 174.3 дахин хувиар өсөж, харин өндөг, шувууны мах, хуурай сүү төмсний импорт 9.3-96.3 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 7. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импорт, мян.ам доллар

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2018 I-IV		2019 I-IV		2020* I-IV		2020* I-IV / 2019 I-IV %	
		Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
Улаан буудай	мян.тонн	167.9	32 854.9	0.4	97.2	71.0	13 929.7	174.3 ¹	143.3 ¹
Гахайн мах	тонн	2 568.0	3 579.1	848.0	1 527.9	1 896.3	4 240.0	2.2 ¹	2.8 ¹
Шувууны мах	тонн	3 138.0	5 633.6	3 709.1	7 383.7	3 252.5	5 921.9	87.7	80.2
Өндөг	сая.шир	45.4	3 302.8	46.6	3 266.0	42.3	2 822.9	90.7	86.4
Төмс	тонн	617.1	158.3	108.8	17.3	4.0	0.8	3.7	4.6
Хуурай сүү	тонн	2 125.5	5 722.2	2 855.2	7 184.3	1 238.7	3 744.0	43.4	52.1
Цагаан будаа	тонн	9 618.0	5 924.7	9 221.0	5 089.1	10 312.1	5 516.2	111.8	108.4
Ургамлын тос	тонн	4 517.0	4 373.3	4 139.3	3 728.6	5 067.9	4 508.1	122.4	120.9
Элсэн чихэр	тонн	18 612.8	8 874.6	15 773.2	6 954.2	24 923.2	10 188.5	158.0	146.5

6. ААНБ, ИРГЭДЭД ОЛГОСОН НИЙТ ЗЭЭЛ

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 4 дүгээр сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 7.6 (0.04%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 514.5 (2.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.7 (50.9%) их наяд төгрөг нь иргэдийнх байна.

Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 4 дүгээр сарын эцэст 14.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 187.4 (1.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 762.5 (5.2%) тэрбум төгрөгөөр буурчээ. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 81.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.9 пунктээр буурсан байна.

Хүснэгт 8. ААНБ, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, зээлийн ангиллаар, сарын эцэст, тэрбум төгрөг

	2017 IV	2018 IV	2019 IV	2020* IV	2020* IV / 2019 IV
	тэрбум төгрөг				хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	12 707.2	14 475.7	17 668.6	17 154.1	97.1
Хэвийн зээл	10 610.6	12 290.2	14 738.4	13 975.9	94.8
Хугацаа хэтэрсэн зээл	1 009.3	978.4	980.3	1 308.3	133.5
Чанаргүй зээл	1 087.3	1 207.0	1 949.9	1 869.9	95.9

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 4 дүгээр сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 158.0 (13.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 328.0 (33.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.1 пунктээр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 4 дүгээр сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 37.0 (2.0%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 80.0 (4.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна.

7. ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛ

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартой харьцах сарын дундаж ханш 2020 оны 4 дүгээр сард 2783.16 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар, өмнөх сараас 0.5 хувиар суларсан байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2020 оны 4 дүгээр сард 393.46 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар суларч, өмнөх сараас 0.3 хувиар чангарсан байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2020 оны 4 дүгээр сард 37.06 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар, өмнөх сараас 1.1 хувиар чангарсан байна.

Хүснэгт 9. Монголбанкнаас зарласан төгрөгийн гадаад валюттай харьцах сарын дундаж ханш, төгрөгөөр, жил бүрийн 4 дүгээр сард

Үзүүлэлт	2017 IV	2018 IV	2019 IV	2020 I	2020 III	2020 IV	2020.V.24
Америк доллар	2 421.85	2 394.65	2 634.93	2744.38	2769.03	2 783.16	2 801.20
Жилийн өөрчлөлт,%	20.4	-1.1	10.0	3.6	5.2	5.6	
Сарын өөрчлөлт,%	-1.5	0.03	0.1	0.6	0.5	0.5	
Евро	2 594.75	2 941.41	2 961.39	3046.97	3067.13	3 024.66	3 054.29
Жилийн өөрчлөлт, %	13.7	13.4	0.7	0.6	2.9	2.1	
Сарын өөрчлөлт,%	-1.4	-0.4	-0.6	0.5	1.9	-1.4	
Юань	351.44	380.11	392.28	396.46	394.57	393.46	392.60
Жилийн өөрчлөлт,%	13.1	8.2	3.2	1.6	0.6	0.3	
Сарын өөрчлөлт,%	-1.4	0.3	-0.01	2	0.1	-0.3	
Рубль	42.89	39.4	40.78	44.34	37.46	37.06	38.91
Жилийн өөрчлөлт,%	42.1	-8.1	3.5	11.9	-7.5	-9.1	
Сарын өөрчлөлт,%	0.9	-6.1	0.7	2.2	-13.2	-1.1	

8. АЧАА БОЛОН ЗОРЧИГЧ ТЭЭВЭР


ДЭМБ-аас онц байдал зарласнаар олон улсын нислэгүүд цуцлагдаж, улсууд гаднын иргэдийг нэвтрүүлэхгүй байх шийдвэр гаргаж, Монгол Улс ч хилээр орох, гарах урсгалыг хязгаарлаад зогсохгүй дотооддоо хөл хорио тогтоогоод байна. Үүнээс шалтгаалан улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2020 оны эхний улиралд 10.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.1 (33.4%) сая тонноор буурч, 29.1 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь 13.4 (31.4%) сая хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 5.6 (64.2%) сая тонноор, авто тээврээр зорчигчид 13.2 (31.6%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 10. Авто тээврийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2017 I-III	2018 I-III	2019 I-III	2020* I-III	Ачаа тээврийн бууралтад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр 5.4 сая тонн буюу 68.4 хувиар, зорчигч тээврийн хувьд нийслэлийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 12.9 (33.7%) сая хүнээр буурсан нь нөлөөлсөн байна.
Тээсэн ачаа, сая тонн	7.5	7.3	8.8	3.1	
Уул уурхайн бүтээгдэхүүн	6.7	6.5	7.9	2.5	
Зорчигчид, сая хүн	44.3	46.4	41.6	28.5	
Нийслэлийн нийтийн тээвэр	40.8	42.8	38.3	25.4	
Тээврийн орлого, тэрбум төгрөг	119.4	135.8	160.9	85.9	

Авто тээврийн салбарын орлого 2020 оны эхний улиралд 85.9 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 75.0 (46.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 138.3 (61.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.


Зураг 7. Төмөр замын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



нөлөөлсөн байна.

Мөн түүнчлэн хот хоорондын хөл хорио тогтоосны улмаас төмөр замаар зорчигчдын тоо 2020 оны эхний улиралд 447.0 (давхардсан тоо) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 115.6 (20.5%) мянган хүнээр буурсан байна. Төмөр замын тээврээр зорчигчдын тоо буурахад орон нутгийн зорчигчид 108.4 (19.9%) мянган хүнээр буурсан нь

Зураг 8. Агаарын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Агаарын тээврээр 2020 оны эхний улиралд давхардсан тоогоор 214.6 мянган хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 85.7 (28.5%) мянган хүнээр буурсан байна. Агаарын тээврээр энэ оны 3 дугаар сард өмнөх сараас 34.8 (51.9%) мянган хүнээр бага буюу 32.2 мянган хүн зорчсон байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2020 оны эхний улиралд 130.3 (60.7%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 74.2 (36.3%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Улаанбаатар-Бээжин чиглэлийн зорчигчид 67.3 хувь, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн зорчигчид 52.8 хувь, Улаанбаатар-Бангкок чиглэлийн зорчигчид 45.8 хувь, Улаанбаатар-Хайлаар чиглэлийн зорчигчид 54.1 хувь, Улаанбаатар-Гонконг чиглэлийн зорчигчид 45.8 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны эхний улиралд 51.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 40.8 (44.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

9. БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА


Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ын 40 хувь нь худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг.

Худалдааны салбарын нийт борлуулалт 2020 оны эхний улиралд сард 4.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар буурсан байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 45.2 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байгаа ба жижиглэн худалдааны борлуулалтын орлого энэ оны эхний улиралд 2.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 290.9 (11.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Улаанбаатар хотод нийт худалдааны салбарын 84.3 хувь ногдож байгаа бөгөөд Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалт 7.1 хувиар буураад байна.


Зураг 9. Худалдааны салбарын нийт борлуулалт, тэрбум төгрөг




10. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАР

Нийтийн хоолны салбарын орлого 2020 оны эхний улиралд 102.9 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 25.9 (20.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Хэдийгээр 2020 оны 1, 2 дугаар сард нийтийн хоолны салбар хэвийн ажиллаж байсан ч коронавирусны халдвар дэгдэхээс урьдчилан сэргийлж, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/223 тоот захирамжийн дагуу бүх төрлийн баар, бүжгийн клубийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, ресторан болон бусад нийтийн хоолны газруудын ажиллах цагийн хуваарийг багасгаснаар рестораны орлого 18.2 хувь, баарны үйл ажиллагааны орлого 64.9 хувь, кафены орлого 27.7 хувь, гуанзны орлого 26.6 хувь, захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээ 8.8 хувиар буурахад хүргэсэн байна.


Зураг 10. Рестораны орлого, улирлаар, тэрбум төгрөг




Зураг 11. Кафены орлого, улирлаар, тэрбум төгрөг



Зураг 12. Баарны орлого, улирлаар, тэрбум төгрөг



Зураг 13. Гуанзны орлого, улирлаар, тэрбум төгрөг



Нийтийн хоолны салбарын орлогын 60.8 хувийг ресторан, 24.6 хувийг захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээ, 6.9 хувийг кафе, 6.0 хувийг гуанз, 1.7 хувийг баарны үйл ажиллагааны орлого эзэлж байна.

11. ЗОЧИД БУУДАЛ

Зочид буудлын салбарын орлого 2020 оны эхний улиралд онд 35.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.5 (42.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх улирлаас 44.9 (56.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд 3, түүнээс дээш одтой буудлын орлого 22.0 (45.6%) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудлын орлого 3.9 (32.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын орлогод 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 74.4 хувийг эзэлдэг. Аялал жуулчлалын салбарын улирлын нөлөөллөөс шалтгаалан жил бүрийн эхний улиралд 3

ба түүнээс дээш одтой буудлын орлого буурдаг ч сүүлийн жилүүдэд салбарын орлого өсөх трендтэй байсан. Энэ оны хувьд 2 дугаар улиралд ч мөн гадаадын жуулчид хүлээн авахгүй учир зочид буудлын салбарын орлого төдийлөн нэмэгдэхгүй байх магадлалтай байна.

Зураг 14. Зочид буудлын салбарын орлого, буудлын зэрэглэлээр, улирлаар, тэрбум төгрөг



12. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Коронавируст халдвар (COVID-19) дэлхий дахинд гарсантай холбогдуулан Монгол Улсын хилийн боомтуудыг 2 дугаар сарын 1-ний өдрөөс хааж эхэлсэн. Энэ оны 2-р сард Монгол Улсын 31 иргэн агаарын боомтоор, 3939 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар орсон бол 3-р сард Монгол Улсын 1830 иргэн тусгай үүргийн нислэгээр, 296 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар тус тус ирсэн байна.


Хавирга боомтыг энэ оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс, Замын-Үүд, Баянхошуу, Бичигт, Булган, Гашуунсухайт, Ханги, Шивээхүрэн боомтуудыг 2 дугаар сарын 1-ний өдрөөс, Буянт-Ухаа боомтыг 2 дугаар сарын 15-ны өдрөөс, Алтанбулаг, Арц суурь, Боршоо, Тэс, Ульхан, Ханх, Цагааннуур, Сүхбаатар, Эрээнцав боомтуудыг 3 дугаар сарын 23-ний өдрөөс тус тус хаасан байна.

Манай улсын хилээр 2020 оны эхний улиралд 551.9 (давхардсан тоогоор) мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 712.3 (56.3%) мянгаар буурчээ. Улсын хилээр орсон зорчигчдын 85.5% нь Монгол Улсын иргэд, 14.5% нь гадаад улсын иргэд байна.

Улсын хилээр 2020 оны эхний улиралд гадаадын 41.2 мянган хүн орсны 88.6% нь аялал жуулчлалын зорилгоор ирсэн байна. Аялал жуулчлалын зорилгоор хилээр орж ирсэн гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 38.9 (51.6%) мянгаар буурсан байна.

Коронавируст халдварын тархалт цаашид хэдий болтол үргэлжлэх нь тодорхой бус байна. Одоогийн байдлаар Монгол Улсын хилийн боомтуудыг 6 дугаар сарыг дуустал нээхгүй байх шийдвэр гараад байна. Үүнээс шалтгаалан аялал жуулчлалын салбар нэлээд хүнд байдалд орох нь тодорхой боллоо.

Зураг 15. Улсын хилээр орсон жуулчдын тоо, улирлаар



Гадаадын жуулчдын 2019 онд ирсэн улирлаар харвал 13.1 хувь нь I улиралд, 24.6 хувь нь II улиралд, 45.1 хувь нь III улиралд, 17.2 хувь нь IV улиралд ирж байжээ.

Аялал жуулчлалын салбарт 2019 оны байдлаар 1255 ААНБ үйл ажиллагаа эрхэлж байсан ба үүсээд буй нөхцөл байдлыг хохирол багатай давахын тулд эдгээр ААНБ-үүд дотоодын аялал жуулчлалын салбарт түлхүү анхаарах хэрэгтэй.

13. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2020 оны эхний 4 сард 7.5 мянган хүнд 17.0 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авагчид 527 (7.6%) хүнээр, олгосон тэтгэмжийн хэмжээ 4.8 (39.0%) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалд даатгуулагчид 2020 оны эхний улиралд 868.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурахад сайн дураар даатгуулагчид 120.9 мянга болж, 17.4 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн сангаас 2020 оны эхний 4 сард 352.1 мянган хүнд 103.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 0.8 хувиар өсөж, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 11.6 хувиар нэмэгджээ. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авсан хүний тоо нэмэгдэхэд "Нийгмийн халамжийн тэтгэмж" авсан хүний тоо 2.5 (3.1%) мянгаар нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.


Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж авагчид энэ оны эхний улиралд 29.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.1 (3.8%) мянга, олгосон тэтгэмжийн хэмжээ 9.1 тэрбум төгрөг болж, 1.2 (14.9%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

14. ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2020 оны эхний улирлын дүнгээр нэг өрхийн сарын дундаж бодит орлого 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 134.1 (12.6%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 74.6 (6.6%) мянган төгрөгөөр өссөн байна. Өрхийн орлого өсөхөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, тэтгэврийн хэмжээг 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт өрхийн 50 орчим хувь нь 2019 оны эхний улиралд 900.0 мянган төгрөг хүртэл орлоготой байсан бол энэ онд 1.1 сая төгрөг хүртэл орлоготой болсон байна.

Зураг 16. Мөнгөн орлогын бүлэглэлт, өрхийн дүнд эзлэх хувь, 2019, 2020 оны эхний улирлаар




Нэг өрхийн сарын дундаж бодит нийт зарлагын хэмжээ 2020 оны эхний улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 114.0 (10.1%) мянган төгрөгөөр, өмнөх улирлаас 62.6 (5.3%) мянган төгрөгөөр өссөн байна. Өрхийн сарын дундаж зарлага өсөхөд хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 22.3 хувиар, хүнсний бүтээгдэхүүний зарлага 16.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Өрхийн хүнсний бүтээгдэхүүний сарын дундаж зарлагын 32.2 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 23.8 хувийг үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн, 11.9 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг,

7.6 хувийг хүнсний ногоо, булцуут, навчит ургамал, 4.1 хувийг элсэн чихэр, чихэрлэг бүтээгдэхүүн, амттан эзэлж байна.

Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын 11.5 хувийг бэлэн хувцас, гутал, 9.8 хувийг тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар, үйлчилгээ, 5.3 хувийг харилцаа холбооны үйлчилгээ, 4.9 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээ, 4.7 хувийг боловсролын үйлчилгээний зардал эзэлж байна.


Зураг 17. Хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага, зарим нэр төрлөөр, зарлагын дүнд эзлэх хувиар



Өмнөх улиралтай харьцуулахад бэлэн хувцас, гутлын зарлагын эзлэх хувь 2.8 пунктээр буурч, тээврийн хэрэгслийн сэлбэг, засвар, үйлчилгээнийх 0.4 пунктээр, харилцаа холбооны үйлчилгээнийх 0.5 пунктээр, эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлчилгээний зардал 0.8 пунктээр нэмэгдсэн бол боловсролын үйлчилгээний зардлын эзлэх хувь өөрчлөгдөөгүй байна. Эндээс үүсээд буй нөхцөл байдалтай холбогдон өрхийн зарлагын бүтцэт өөрчлөлт орж байгааг харж болохоор байна.

500.0 мянган төгрөг хүртэл зарлагатай өрх 2019 оны эхний улиралд нийт өрхийн 12.9 хувийг, 2.1 сая төгрөгөөс дээш зарлагатай өрх 12.0 хувийг эзэлж байсан бол 2020 оны эхний улиралд 500.0 мянган төгрөг хүртэл зарлагатай өрхийн эзлэх хувь 11.1 болж, 1.8 пунктээр буурч, харин 2.1 сая төгрөгөөс дээш зарлагатай өрхийн эзлэх хувь 19.5 болж, 7.5 пунктээр нэмэгдсэн байна.


Зураг 18. Мөнгөн зарлагын бүлэглэлт, өрхийн дүнд эзлэх хувь, 2019, 2020 оны эхний улирлаар



15. ЭРҮҮЛ МЭНД

Энэ оны эхээр ханиад, томуугийн өвчлөл оргилдоо хүрч, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо өмнөх жилүүдийнхээс нэмэгдсэн. БНХАУ-д “Ковид-19”-ийн халдвар дэгдсэнтэй холбоотойгоор манай улс өнгөрсөн нэгдүгээр сарын 27-ноос бүх төрлийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосны нөлөөгөөр ханиад, томуугийн дэгдэлт намжиж, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо буураад байна.

Зураг 11. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид, мянган хүн



Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид 2020 оны эхний улиралд 225.8 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.6 (1.5%) мянган хүнээр буурсан бол энэ оны 3 дугаар сард 67.6 мянган хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, өмнөх сараас 3.5 (4.9%) мянган хүнээр, өмнөх оны мөн үеэс 16.7 (19.8%) мянган хүнээр буурсан байна.

Хүснэгт 11. Халдварт өвчин, төрлөөр, жил бүрийн эхний улирлын байдлаар

Үзүүлэлт	2019 I-III	2020 I-III	2020 I-III / 2019 I-III %
Халдварт өвчнөөр өвчлөгчид	10 155	9 434	92.9
Цусаар дамжих	118	119	100.8
Вируст гепатит	118	119	100.8
Амьсгалын замаар дамжих	4 185	2 634	62.9
Сүрьеэ	860	870	101.2
Салхин цэцэг	2 936	1 579	53.8
Гар, хөл, амны өвчин	389	185	47.6
Гэдэсний халдварт	892	397	44.5
Цусан суулга	892	397	44.5
Бэлгийн замаар дамжих	3 760	4 883	129.9
Тэмбүү	1 361	1 942	142.7
Гонококкт халдвар	1 361	1 517	111.5
Трихомониаз	1 036	1 422	137.3
ХДХВ/ДОХ	2	2	100.0
Бусад	427	1 118	261.8
Мөөгөнцөр	427	1 106	259.0
Коронавируст халдвар	-	12	-

Эх үүсвэр: ЭМЯ

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2020 оны эхний улиралд 9434 болж, өмнөх оны мөн үеэс 721 (7.1%)-ээр буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварын замын төрлөөр харвал амьсгалын замаар дамжих халдварын тохиолдол 2634 болж, 1551 (37.1%)-ээр, гэдэсний халдварт өвчин 397 болж, 495 (55.5%)-аар тус тус буурсан байна.

Иргэд ЭМЯ-ны заавар, зөвлөгөөг сайн дагаж, гараа тогтмол угаан, амны хаалт зүүж хэвшсэн нь амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчин урьд байгаагүй доод түвшинд хүрч, буурахад нөлөөлсөн байна.

Харин бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол 4883 болж, 1123 (29.9%)-аар нэмэгдсэн байна.

16. ГЭМТ ХЭРЭГ

Монголд хөл хорио тогтоож, өндөржүүлсэн бэлэн байдалд шилжээд 3 сар өнгөрч байна. Үйлчилгээний газар, баар, цэнгээний газруудыг хэсэгчлэн хааж, цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан мөн иргэдийг аль болох гэртээ байхыг уриалж байгаа нь энэ хугацаанд нийт гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлсөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 оны эхний улиралд 8003 болж, өмнөх оны мөн үеэс 1902 (19.2%)-оор буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэрэг 2020 оны 3 дугаар сард 2059 болж, өмнөх сараас 1314 (39.0%)-өөр буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2020 оны эхний улиралд 26 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 133 (83.6%)-аар буурсан байна.

Гэвч нөгөө талдаа гэр бүлийн хүчирхийллийн зөрчил нэмэгдэх шалтгаан болж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2020 оны эхний улиралд 3131 зөрчил бүртгэгдсэний 2244 (71.7%) зөрчлийг шалган шийдвэрлэсэн байна. Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 1193 (61.6%)-аар, шийдвэрлэсэн зөрчил 1118 (99.3%)-аар тус тус өссөн байна.

Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2020 оны эхний улиралд 799 болж, өмнөх оны мөн үеэс 36 (4.7%)-гаар өсөж, улсын хэмжээнд 27.1 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 3.6 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 1.7 (6.0%) мянгаар буурч, харин баривчлагдсан хүн 1.0 (39.8%) мянгаар өссөн байна.

ДҮГНЭЛТ

Олон улсын валютын сангийн Дэлхийн эдийн засгийг 2020 онд 3.3 хувийн өсөлттэй байна гэсэн тооцоолол COVID-19 цар тахлын нөлөөгөөр 3.0 хувь буурах төлөвтэй болж, эрс өөрчлөгдсөн байна. Үүний баталгаа болж БНХАУ-ын эдийн засаг 2020 оны эхний улирлын байдлаар 6.8 хувь, тус улсаас хараат эдийн засагтай Монгол улсын эдийн засаг 10.7 хувь агшаад байна.

COVID-19 цар тахлын дэгдэлт болон БНХАУ-ын эдийн засгийн удаашралын улмаас ашигт малтмалын түүхий эдийн эрэлт багассан нь Монгол Улсын нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, газрын тосны экспорт буурч, эдийн засаг агшихад хүргэсэн байна.

Үүний нөлөөгөөр гадаад худалдааны нөхцөл муудаж, экспорт буурснаар төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал 2020 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 767.0 сая америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 368.9 сая америк доллароор өссөн байна.

Дэлхий нийтийг хамраад буй халдварт өвчний тархалт манай улсын үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлж эхэлж байна. Нэн ялангуяа үйлдвэрлэлийн түүхий эд, материал болон сэлбэг, эд ангиа гаднаас импортолдог цаас, цаасан бүтээгдэхүүн, мод, модон эдлэл, резин болон хуванцар бүтээгдэхүүн, химийн бүтээгдэхүүн, тамхи, тавилга, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын борлуулалт 2020 оны эхний 4 сард 2.5-58.9 хувиар буурсан байна.

ДНБ-ий 10.7 хувийн бууралтын -1.3 пункт нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт ногдож байна. Худалдааны салбарын борлуулалтын орлогын 45.2 хувийг жижиглэн худалдааны салбараас бүрдүүл байгаа ба жижиглэн худалдааны борлуулалтын орлого энэ оны эхний улиралд 2.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар буурсан байна.

Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 2020 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар буурсан. Хэдийгээр 2020 оны 1, 2 дугаар сард үйлчилгээний салбар хэвийн ажиллаж байсан ч коронавирусны халдвар дэгдэхээс урьдчилан сэргийлж, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/223 тоот захирамжийн дагуу бүх төрлийн үйлчилгээний газрын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоож, ресторан болон бусад нийтийн хоолны газруудын ажиллах цагийн хуваарийг багасгаснаар зочид буудлын салбарын нийт орлого 2020 оны эхний улиралд 35.3 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 56.0%, нийтийн хоолны салбарын орлого 102.9 тэрбум төгрөг болж 20.1% буурсан байна.

ДЭМБ-аас онц байдал зарласны дагуу хилээр орох, гарах урсгалыг хязгаарласны дээр дотоодын хөл хорионы улмаас улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2020 оны эхний улиралд 10.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.1 (33.4%) сая тонноор буурч, 29.1 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь 13.4 (31.4%) сая хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 5.6 (64.2%) сая тонноор, зорчигчид 13.2 (31.6%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дийлэнх хувийг бүрдүүлдэг нүүрсний тээврийг автозамаар тээвэрлэдэг ба энэ он гарснаас хойш БНХАУ-руу экспортолж буй нүүрсний хэмжээ огцом буурсан нь авто тээврээр тээсэн ачаа буурахад голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үүнтэй уялдаад банкны системийн хэмжээгээр хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 4 дүгээр сарын эцэст 1.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 33.5 хувиар өсөөд байна.

Энэ оны нэг, хоёрдугаар сард ханиад, томуугийн өвчлөл оргилдоо хүрч, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо өмнөх жилүүдийнхээс нэмэгдэж байсан бол БНХАУ-д “Ковид-19”-ийн халдвар дэгдсэнтэй холбоотойгоор манай улс бүх шатны боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосны нөлөөгөөр ханиад, томуугийн дэгдэлт буурч эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо буураад байна.

Иргэд ЭМЯ-ны заавар, зөвлөгөөг сайн дагаж, гараа тогтмол угаан, амны хаалт зүүж хэвшсэн нь амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчин урьд байгаагүй доод түвшинд хүрч, буурахад нөлөөлсөн байна.

Үйлчилгээний газар, баар, цэнгээний газруудыг хэсэгчлэн хааж, цагийн хуваарьт өөрчлөлт оруулж, иргэдийг аль болох гэртээ байхыг уриалж байгаа нь хөл хорио тогтоогоод буй хугацаанд нийт гэмт хэргийн гаралт буурахад нөлөөлсөн байна.

Гэвч нөгөө талдаа гэр бүлийн хүчирхийллийн зөрчил нэмэгдэх шалтгаан болж, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 61.6 хувиар өссөн байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ҮНДЭСНИЙ ТООЦОО, ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ГАЗРЫН
ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ТҮҮВРИЙН АЛБА